

БАТЛАВ.

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

_____ / _____ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

Агар энерги ХХК-ийн Гүйцэтгэх захирал _____ ХҮДЭРХУЯГ/



**“АГАР ЭНЕРГИ” ХХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
10-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРШИЛТАЙ
УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6423701

ХЯНАСАН:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн _____ / _____ /

БОЛОВСРУУЛСАН:

Агар энерги ХХК-ийн ХАБЭАБО хариуцсан мэргэжилтэн: Б. Алтанхишиг /Б. АЛТАНХИШИГ/

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

АГУУЛГА	
ОРШИЛ	2
ХОЁР. УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2.1 Үйлдвэрийн тоног төхөөрөмж	4
ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
3.1 Талбайн байршил	5
3.2 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	6
3.3 Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт	7
ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	9
ЗУРГАА. 2026 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭХ АЖЛУУД	10
6.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6.2 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6.4 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
6.5 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
6.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	12
6.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
6.8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6.9 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	14
МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	15

ОРШИЛ

Агар энерги ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үйлдвэр байрлах нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгын хүрээнд боловсрууллаа.

Агар энерги ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн нутаг дахь “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн /М-Си-Эс Кока-Кола үйлдвэрт уур, ус, хий нийлүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж/ Төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг 2025 оны 10-р сарын 28-ны өдрийн №10/5544 тоот дүгнэлтээр баталгаажуулсан.

Агар энерги ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрлах “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн /М-Си-Эс Кока-Кола үйлдвэрийг технологийн уур, дулаан, хүнсний зориулалттай хийгээр хангах/ Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Глобал энвайрон” ХХК гүйцэтгэсэн бөгөөд Тайлан болон 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг /2026-2030/ 2026 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан бөгөөд БОУАӨЯ-ны Ерөнхий шинжээч баталгаажуулсан болно.

Тус компани 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОУАӨЯ-аар 2025 оны 1 сард батлуулан, БЗД-ийн 26-р хорооны Нийслэлийн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 30 ширхэг голт бор модыг тарьж, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлийн ажлуудыг гүйцэтгэн, Нийслэлийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах ажлын хэсгийн үнэлгээгээр 94.5%-тай үнэлэгдсэн.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, төслийн 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө /2026-2030/, Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, шинжилгээний дүн, БОУАӨЯ-ны сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав. Энэхүү төлөвлөгөөгөөр “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилт, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоосон болно. 2026 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хэрэгжих ажлуудыг нийт **8,734,000** төгрөгийн зардал гарган хийхээр тооцооллоо.

ХОЁР. УУРЫН ЗУУХ БОЛОН НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Агар энерги компанийн Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр нь “М-Си-Эс Кока-Кола” ус ундааны үйлдвэрийг технологийн уур, халаалт, хэрэгцээний халуун ус, хүнсний зориулалттай нүүрсхүчлийн хийгээр хангах үйл ажиллагаа явуулдаг.

2019-2020 онд “М-Си-Эс Кока-Кола” компанийн ашиглаж байсан нүүрсээр ажилладаг хуучин зуухыг шингэрүүлсэн нефтийн хийгээр ажилладаг зуухаар сольж өөрчлөн шинэчилснээр тус үйлдвэрийг найдвартай, тасралтгүй уур, дулаан болон хүнсний зориулалттай нүүрсхүчлийн хийгээр хангах, байгаль орчинд сөрөг нөлөө багатай үйлдвэрлэл явуулах боломжийг бүрдүүлсэн. Үйлдвэр 2020 оны 10 сард ашиглалтад орсноор


- М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн нүүрсээр ажилладаг зуухнуудыг орчин үеийн, ашигт ажиллагаа өндөртэй, шинэ зуухнуудаар шинэчилсэн.
- Үйлдвэрлэлийн технологийн процесст нэн шаардлагатай технологийн уур, нүүрсхүчлийн хийгээр найдвартай хангах боломж бүрдсэн.
- Уламжлалт түүхий нүүрсний хэрэглээг тэглэж, агаар болон орчинд хаягдах хорт бодис, нарийн ширхэглэгт тоосонцор буюу хатуу хог хаягдлыг байхгүй болгосноос гадна хүлэмжийн хийн ялгаралтыг үлэмж хэмжээгээр бууруулсан.
- Агаарын бохирдлыг бууруулах Засгийн газар, Нийслэлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн жишиг зуухны газар бий болсон.

2024-2025 онд М-Си-Эс Кока-Кола ус, ундааны шинэ Асептик үйлдвэрийн технологийн уурын хэрэгцээг хангах нэмэлт өргөтгөл хийгдэж БНХАУ-д үйлдвэрлэсэн шингэрүүлсэн нефтийн хийгээр ажилладаг WNS8-1.6-Q загварын 8 тн/цаг уур үйлдвэрлэх хүчин чадал бүхий 3 ширхэг уурын зуух суурилуулан ашиглаж байна.

Компанийн нэр, хаяг:

“Агар энерги” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011391089
Регистрийн дугаар: 6423701
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, олимп 19а, Шангри-Ла оффис
7 давхар, 704 тоот
Утас: 77226262,

Зураг 1. Үйлдвэрийн план зураг, үндсэн тоног төхөөрөмжийн байршил



2.1 Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Зуухны газар:

- Цагт 4 тн уур үйлдвэрлэх хүчин чадалтай БНСУ-ын DAEYEOL компанид үйлдвэрлэсэн DRH-400PG загварын нийт 4 ширхэг уурын зуух
- Цагт 0.63 Гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай Япон улсын NTEC компанид үйлдвэрлэсэн HGTL-630A загварын нийт 8 ширхэг ус халаах зуух
- Цагт 8 тн уур үйлдвэрлэх хүчин чадалтай БНХАУ-дын Зозен бойлер компанид үйлдвэрлэсэн WNS8-1.6-Q загварын нийт 3 ширхэг уурын зуух
- Зуухны хийн түлшийг дамжуулах “Юнигаз” ХХК-ийн импортын агуулах дахь хадгалах банкаас нийт 180 м урт, ф57 мм ган хоолой
- Шингэрүүлсэн нефтийн хийг буцаан хийн төлөвт шилжүүлэх ууршуулах төхөөрөмж
- Бусад тоноглолууд

Зуухны барилгад үндсэн уурын болон ус халаах зуухнаас гадна деаэратор, тэжээлийн усны насосууд, үлээлгийн бак, конденсат цуглуулах бак, тэлэлтийн сав болон тэдгээрийн хоорондын халуун ус ба уурын шугам хоолой, холбох хэрэгсэл, таслах болон тохируулах хаалтууд, хянах хэмжих хэрэгслүүд угсрагдсан. Мөн цахилгаан тэжээлийн болон удирдлага, дохиоллын болон тэжээлийн кабель, кабелийн трассуудыг угсарч байрлуулсан.

Нүүрсхүчлийн хийн аж ахуй:

Энэ үйлдвэр нь нүүрсхүчлийн хийг (CO₂) олборлох, цэвэршүүлэх, шингэрүүлэх технологиор дэлхийд тэргүүлэгч болох Дани улсын Юнион инженеринг компанийн EBU 500 загварын иж бүрэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Үйлдвэрт технологийн уур үйлдвэрлэх уурын зуухны шингэрүүлсэн нефтийн хийн шаталтаас ялгарах утааны хийнээс CO₂-г ялган авна. Үйлдвэр нь цагт 500 кг цэвэршүүлсэн CO₂ үйлдвэрлэх хүчин чадалтай. Үйлдвэрлэж буй CO₂-н цэвэршилт 99.99%-99.997% байдаг.

Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаа автомат системээр хянагдан удирдагдах бөгөөд удирдлагын систем нь хамгийн сүүлийн үеийн PLC технологи болон TFT өнгөт самбарыг ашигладаг. Үйлдвэрийн удирдлагын самбар дээр үйлдвэрлэлийн явц, мэдээлэл гаран, хадгалагдах ба анхааруулах, мэдээлэх, дохио өгөх зэргээр бүх процессыг хянахаас гадна CO₂-н үйлдвэрлэлийн туршид болон хадгалах танк дахь бүтээгдэхүүнийг Герман улсын “CARBOSCAN 150” байнгын хяналтын төхөөрөмжөөр CO₂ дахь нийт 17 нэгдлийг тасралтгүй шинжилдэг.

ГУРАВ. ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Талбайн байршил

“Агар энержи” ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн байршил нь Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт “М-Си-Эс Кока-Кола” ус ундааны үйлдвэрийн хашаанд байрладаг. Уг үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотын төвөөс 8 км-т байрлаж байна.

Хүснэгт 1. Газрын координат

№	X	Y	Цэгүүд	Урт
1	5310038.14	651071.54	1-2	21.57
2	5310058.78	651065.30	2-3	22.48
3	5310064.51	651087.03	3-4	134.87
4	5310195.16	651053.54	4-5	0.53
5	5310195.28	651054.06	5-6	48.94
6	5310242.61	651041.62	6-7	12.90
7	5310255.04	651038.18	7-8	102.91
8	5310281.23	651137.70	8-9	153.66
9	5310315.56	651287.48	9-10	57.06
10	5310259.00	651294.99	10-11	179.81
11	5310081.26	651322.17	11-12	220.07
12	5310025.00	651109.41	12-13	22.38
13	5310046.64	651103.69	13-1	33.25

Зураг 2. Үйлдвэрийн 1:30.000 масштабтай зураглалын (байршил) ерөнхий харагдах байдал



Зураг.3. Үйлдвэрийн зураг



3.2 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт

“Агар энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрлах “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, болзошгүй нөлөөллийн хураангуйг энэ хэсэгт оруулав.

Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	
Газрын гадарга, байр зүй	Судалгааны талбай нь геоморфологийн хэв шинжийн хувьд, уулын бэл хормойн хурдас чулуулгийн зөөгдөл-хуримтлалын гадаргуугийн хэсэгт хамаарагдана. Үйлдвэрийн газар нь далайн түвшнээс дээш 1312 м орших бөгөөд газарзүйн байрлал нь ХӨ 47°54'26,7", ЗУ 107°01'25,2" болно.
Уур амьсгалын нөхцөл	Монгол орны уур амьсгалын мужлалын хувьд авч үзвэл Улаанбаатар хот орчим нь хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. <u>Агаарын температур:</u> Тухайн бүс нутагт жилийн дундаж агаарын температур -4°C орчим байх ба хотын дотор (Тахилт, Улаан хуаран орчим) -1.2 ...-1.5°C, өндөр уулын оройгоор (Хүрэлтогоот, Морин уул) -1...0.8°C гэж одоо мөрдөж байгаа “Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт. БНБД 2.01.01-93”-д гаргасан байна. Туул голын хөндийд -4...-4.20C, үүнээс ч хүйтэн, уулын энгэр, ээвэр газар -4°C-ээс дулаан, ар хойд талдаа үүнээс ч хүйтэн байх жишээтэй. Агаарын температур уул нуруундаа +14°C-аас сэрүүн, голын хөндий нутагт арай дулаан 14-16°C байна. <u>Агаарын чийгшил, хур тунадас:</u> Харьцангуй чийгшил хамгийн дулаан сарын өдрийн 13 цагт 50-60 % байдаг нь энэ орчим нь өндөр чийгшилтэй нутаг юм. Жилийн дундаж харьцангуй 70-75 % хүрч хуурай хаврын улиралд 45-55 % байна. <u>Нарны цацраг, нарны гийгүүлэл:</u> Улаанбаатар хотод жилдээ 2862-2816 цаг нар гийгүүлэх бөгөөд Богд Хан ууланд дунджаар 2800 цаг нар гийгүүлдэг байна. <u>Хур тунадас:</u> Хур борооны дундаж эрчим зуны саруудад 0.05 мм/мин, хамгийн их эрчим VII сардаа 1.28 мм/мин байна. <u>Салхи, агаарын даралт:</u> Хан Хэнтийн нуруу, Туул голын сав газрын салхи нь хойд, баруун хойноос ноёлох чиглэлтэй. Салхины хамгийн их хурд 5-р сард ажиглагдах ба хамгийн намуун үе нь 12,1-р сард тохиолддог. Салхины дундаж хурд 3,21 м/сек боловч голын хөндийд 4,8 м/сек хүртэл нэмэгддэг. Салхины хурд хаврын 4 сард их 1.4-6.3 м/сек, намар 10 сард 0.8-4.7 м/сек хүрч 10 м/сек-ээс их хурдтай салхи 7-10 өдөр тохиолдох магадлалтай.

Агаар, дуу чимээ	Үйлдвэрлэлийн явцад ялгарах бага хэмжээний утаа нь агаарын чанар, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд маш бага хэмжээгээр сөргөөр нөлөөлж болзошгүй. Тухайн орчны дуу чимээний хэмжилтийг 2025 оны 4 сарын 22-нд хийсэн. Хэмжилтийг төслийн талбай дээр, байгалийн нөлөө /салхи/, хүний үйл ажиллагааны нөлөө /харилцан яриа, тоног төхөөрөмж/ зэрэг хүчин зүйлийг тусган өнөөгийн бодит дуу чимээний түвшнийг тодорхойлсон. Дуу чимээний дундаж утгын түвшин Монгол улсын MNS4585:2017 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа ба дуу чимээний хамгийн их утга тоног төхөөрөмжийн хажууд хийсэн хэмжилт юм.
Ус	Төслийн талбай орчимд гадаргын ил задгай ус байхгүй учир гадаргын усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх боломжтой.
Хөрс	Машин, техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, тослох материалын асгаралт зэрэг нь хөрсөнд шууд нөлөөлөх
Ургамлан	Уурын зуухны ойр орчим нь суурьшлын бүс учраас хөрс эвдрэлд өртөж, үүссэн тоосжилт нь ургамлын бүрхэвч дээр бууж хуримтлагдсанаар ургамлын фотосинтезийн бүтээмжид сөргөөр нөлөөлж урт хугацаанд ургамлын ургах чадварыг алдагдуулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.
Амьтан	Үйлдвэрийн үйл ажиллагааны ойролцоо үйлдвэрийн барилгуудтай төвлөрсөн бүс учраас томоохон зэрлэг амьтад үргэн дайжсан бөгөөд тэдгээрт нөлөөлөл байхгүй
Тусгай хамгаалалттай газар нутаг	Үйлдвэрийн талбай орчимд улсын болоод орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг үгүй болно.

3.3 Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт

Нийгэм эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт	
мэдээлэл	<u>Дүүргийн гол онцлог:</u> - Нийслэлд хүн амын тоогоор тэргүүлдэг - Нутаг дэвсгэрийн хэмжээ их - Хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд их - Мал аж ахуй бусдаас илүү - Шинжлэх ухааны байгууллага олон - Их дээд сургууль олон - Цэргийн байгууллага олон - Байшин болон гэр хороолол хосолсон <u>Нутаг дэвсгэр, газар зүйн онцлог</u> Баянзүрх дүүрэг 124.4 мянган га газар нутагтай, Богд хан уулын Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурахын ам, Хар усан тохой зэрэг ан амьтан, цэцэг жимс, ой мод, рашаан ус, эмийн ургамал бүхий үзэсгэлэнт сайхан байгальтай юм. Гоёмсог барилга, өргөн гудамж, зам талбай, гүүр, хөшөө дурсгал бүхий хотын шинжийг агуулсны сацуу уул толгод, ой хөвч, тал хээрийг багтаасан үзэсгэлэнт байгаль бүхий Нийслэл хотын хамгийн том дүүрэг юм. Дүүргийн нутаг дэвсгэрт 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 151 нь төсвийн, 420 нь төрийн бус байгууллага бол 18 нь хувьцаат компани, 3345 нь ХХК юм. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар 49, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 13 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг.
Оршин суугчид	Тус аж ахуйн талбайн хойд талд Юнигаз ХХК-ийн агуулах байрлах ба эргэн тойрон үйлдвэрлэл төвлөрсөн бүс юм. Үйлдвэр талбайн зүүн талд Баянзүрх дүүргийн 10-р хорооны оршин суугчид байх ба “М-Си-Эс Кока-Кола” ХХК-ийн үйлдвэрийн бүсэд ажилчид ажилладаг болно.
Хүний эрүүл мэнд	Тухайн үйлдвэр нь дээрх дурдсан оршин суугчид, ажилчид болон орчны агаарын чанарыг сайжруулах төсөл болж байгаа бөгөөд хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл бага юм.
Бусад төсөл	Дүүргийн нутаг дэвсгэрт 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 151 нь төсвийн, 420 нь төрийн бус байгууллага бол 18 нь хувьцаат компани, 3345 нь ХХК юм. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар 49, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 13 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг.

**ДӨРӨВ. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

“Агар энерги” ХХК-ийн “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Үүнд:

Агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Хийн алдагдал үүсэх болзошгүй нөхцөл

Усны чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас хөрсөнд нэвчин уст үеийг бохирдуулах.

Хөрсний чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Химийн бодис, тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

Хүснэгт 2. Аж ахуйн гол сөрөг нөлөөлөл

Түвшин	Зэрэг	Тайлбар		
		Сөрөг нөлөөлөл	Хөрөнгө	Шийдэл
V	Лавтай болох	Ашиглалтын үеийн химийн бодисын хэрэглээ	Н-Дунд хохирол	Үйлдвэрийн технологийн болон химийн бодисын хэрэглээний үеийн зааврыг чанд сахин мөрдөж ажиллах
IV	Магад болох	Химийн бодисын сав, уутны хаягдал үүсэх	М-Бага хохирол	Химийн бодисын сав, уут боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах
III	Болзошгүй	Дуу чимээ, доргионы бохирдол	М-Бага хохирол	Үйлдвэрийн тоног төхөөрөмжид доргио, чичиргээнээс үүсэх нөлөөллийг багасгаж зөөлөвч хийх
I	Бараг болохгүй	Хийн тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад үүсэх болзошгүй хий алдагдах, гал түймэр зэрэг нөлөөлөл	Н-Их хохирол	Технологийн аюулгүй байдлыг чанд сахин ажиллах, гэнэтийн аюул ослоос сэргийлсэн автомат аваарын төхөөрөмжүүдийг тоноглолын дамжлага бүрд суурилуулан байнга хянаж ажиллах

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан болон үйлдвэрийн талбайд хийсэн шинжилгээний дүн зэргийг үндэслэн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний голлох зорилтуудыг дэвшүүлж байна.

Үүнд:

- Үйлдвэрлэлийн орчны ногоон байгууламжийг арчлах, ургуулах, зүлэгжүүлэлт хийх
- Хавар, намрын улиралд шар өвсний гал түймрээс сэргийлэн үйлдвэрийн ойр орчмын цэвэрлэгээ хийх
- БЗД-ийнхээ нутаг дэвсгэр дээр 30 ширхэг мод тарих, ногоон байгууламжийн ажилд оролцох
- Үйлдвэр болон оффисоос гарч буй хог хаягдлуудыг ангилан ялгаж хаях, хог хаягдлын тоо мэдээллийг бүртгэх баримтжуулах
- Химийн бодисын сав, баглааны хаягдлыг холбогдох журмын дагуу зайлуулж бүртгэх, хэмжих хог хаягдал зайлуулах гэрээг ахин сунгаж хүлээлгэн өгөх

Хэдийгээр үйлдвэрийн үйл ажиллагаа нь байгаль орчинд үзүүлэх хүчтэй, том хэмжээний талбайг хамарсан нөлөөлөл үүсэхгүй боловч бичил экосистемд үзүүлэх бага хэмжээний нөлөөллийг бүрэн арилгаж ажиллах нь зүйтэй юм.

Үйлдвэрийн ажилчдын болгоомжгүй санамсаргүй үйл ажиллагаанаас үүдэлтэй томоохон хэмжээний аюул, осол гарч болзошгүй бөгөөд эрсдэлийн үнэлгээний хэсэгт заасны дагуу технологийн заавар, дүрэм, санамж зэргийг байнга даган мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай болно.

Монгол Улсын УИХ-аас 2014 онд батлагдсан 43-р тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлогын” 3.3.4.-д байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн ногоон татварын системийг бий болгох гэж заасны дагуу ногоон үйлдвэрлэл, худалдааг дэмжин ажиллах нь гол юм.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, холбогдох сургалтуудыг тогтмол зохион байгуулах
- Ашигласан химийн бодисын сав, баглааг зөв хадгалж, гэрээний дагуу зайлуулах

ЗУРГАА. 2026 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДЭХ АЖЛУУД

6.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төлөвлөгөөний гол зорилго нь дээр тодорхойлсон голлох сөрөг нөлөөллүүдийг бууруулахад оршино. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх аж ахуйн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт зэргийг үндэслэн хийв. Зардлын хэмжээг дараах байдлаар гаргалаа.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах									
1	Хийн зуухнаас гарч болзошгүй хорт хийнүүд	Хийн зуухны гаралтын хэсэгт хийн хэмжилт хийлгэх, гарч болзошгүй хийд хяналт тавьж ажиллах	Хийн зуухны байгууламжийн орчинд	Дотоод төлөвлөлтөөр				4 цаг тутам	БОНБНҮТ
2	Хийн зуухнаас дотоод орчинд хорт хий тархаж болзошгүй эрсдэл	Хийн зуухны дотоод орчин хэсэгт хийн хэмжилт хийх, гарч болзошгүй хийд хяналт тавьж ажиллах	Хийн зуухны байгууламжийн дотоод орчинд	ш	1000000	1	1000000	тогтмол	БОНБНҮТ
2. Хөрсний бохирдлоос хамгаалах ажил									
1	Байгальд үүсэх болзошгүй асгаралт	Хөрсний хяналт-шинжилгээг заасан цэгт хийж байх	Үйлдвэрийн талбай	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгасан				улирал бүр	БОНБНҮТ
2	Хөрс орчин бохирдуулах үйл ажиллагаа	Технологийн бүх шатанд хоргүйжүүлэх, ариутгах ажиллагааг бүрэн хийж ажиллах ба хог хаягдлыг зохих заавар шаардлагын дагуу, зөвшөөрөгдсөн газарт хаях		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан				тогтмол	БОНБНҮТ
3. Усан орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах									
1	Цэвэр усны хэрэглээ	М-Си-Эс Кока-Кола ХХК-ийн цэвэршүүлсэн саарал усыг үйлдвэрийн зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Үйлдвэрийн талбай	Дотоод төлөвлөлтөөр				5-9 сар	БОНБНҮТ

2	Болзошгүй байгалийн гамшгийн аюул	Үер болон борооны усаар зөөгдөн элдэв хог хаягдал хөрсөнд шингээгдэхээс сэргийлж үерийн ус зайлуулах сувгийг цэвэрлэж байх	Үйлдвэрийн талбай	Дотоод төлөвлөлтөөр	Борооны улирал эхлэхээс өмнө	БОНБНҮТ
3	Үйлдвэрийн хаягдал ус	Үйлдвэрийн хаягдал усны чанарын шинжилгээг улирал бүр хийлгэх	Үйлдвэрийн талбай	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгасан	улирал бүр	Усны тухай хууль
Нийт			1000000			

6.2 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламжийг нэмэгдүүлж агаарын бохирдлыг бууруулах	Өмнө тарьсан мод болон зүлэгийг арчлах	Үйлдвэрийн талбай	ш	25	10000	250000	5-9 сард	-
2	БЗД-ийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	БЗД-ийн нутаг дэвсгэр дээр мод тарих	БЗД-ийн нутаг дэвсгэр	ш	30	50000	1500000	9 сард	-
Нийт					1750000				

6.3 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн талбай орчим нь олон жилийн туршид хүн суурьшиж ирсэн бөгөөд одоог хүртэл хийсэн архелогийн судалгаанаас үзвэл түүхийн олдвор, дурсгалт зүйл газар үгүй.

6.4 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хийн тоног төхөөрөмжийн буруу ашиглалт	Технологийн заавар, аюулгүй ажиллах журмыг шинэчлэх, мөрдөх, галын аюулаас сэргийлэх, тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ хийх	Үйлдвэрийн талбай	Дотоод төлөвлөлтөөр			тогтмол	ХААААД, технологийн заавар
2	Химийн бодисын хадгалалт,	Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтад Химич нарыг хамруулах		2	200000	400000	2026	ХХБАБТХ

3	тээвэрлэлтийн явцад учрах эрсдэл	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах сургалтыг дотооддоо ажилчдад орох		Дотоод төлөвлөлтөөр	2026	
4		Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих.		Дотоод төлөвлөлтөөр	тогтмол	
5	Химийн бодисын ашиглалтаас үүсэх болзошгүй эрсдэл	Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх.		Дотоод төлөвлөлтөөр	тогтмол	
	Нийт			400000		

6.5 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлыг ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэг, хаягдал боловсруулах үйлдвэрт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн хог хаягдлын ангилан ялгалтанд хяналт тавих, хог хаягдлыг зайлуулж, устгуулах	Үйлдвэрийн талбай	сар	20000	12	240000	тогтмол	ХХТХ
2	Үйлдвэрийн	Химийн бодисын ашиглалтаас үүссэн сав баглааг зохих журмын дагуу зөв зайлуулж, бүртгэж тооцох		сар	67000	12	804000	тогтмол	ХХБАБТХ
3	Аюултай	Химийн бодисын ашиглалтаас үүссэн аюултай материалыг зохих журмын дагуу мэргэжлийн байгууллагаар зөв зайлуулж, устгуулах		Үйлдвэрийн зардлаас					тогтмол
	Нийт		1044000						

6.6 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр							
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	2 цэг	Улирал бүр	4	60000	240000	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 :2008
2	Хөрсний агрохимийн найрлага	2 цэг		4	68500	274000	
3	Хөрсөн дэх хүнд металл	2 цэг		4	45000	180000	
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр							

1	Агаар дахь тоосжилтын агууламж	2 цэг	Улирал бүр	4	49500	396000	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.
Усны хяналт шинжилгээний хөтөлбөр							
1	Үйлдвэрийн хаягдал усны хүнд металлын агууламж	1	Улиралд бүр	8	150000	1200000	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага, MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
Нийт				2290000			

Зураг.4 Орчны шинжилгээний цэг Үүнд: А – Агаарын дээж 2, Х – Хөрсний дээж 2



6.7 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хариуцсан албан тушаал
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	300000	Үйлдвэрийн менежер ХАБЭА-н мэргэжилтэн
2	Ажилчдын ур чадвар, мэдлэг мэдээллийг дээшлүүлэхээр сургалт зохион байгуулах	600000	
3	Ус ашиглах болон хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авах	1200000	
Нийт		2100000	

6.8 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	БЗД-ийн 10-р хорооны ИНХ	Аман тайлан	Тухайн жилийн БОМТ, тайлан	10-р сарын 25	50000	Үйлдвэрийн менежер, ХАБЭА-н мэргэжилтэн	Хорооны ИНХ байр
2	Нийслэлийн БОГ-т	Бичгэн тайлан		10-р сарын 30	50000		Нийслэлийн БОГ БОУАӨЯ
3	БОУАӨЯ-д			12-р сарын 5	50000		
	Нийт				150000		

6.9 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалтай хийгдэх ажлуудыг тооцож үзэхэд 2026 онд нийт **8,734,000** төгрөг зарцуулах тооцоо гарч байна.

№	2026 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	Зардлын хэмжээ	Тайлбар
1	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	1000000	
2	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	2290000	
3	ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	1750000	
4	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	-	
5	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	400000	
6	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	1044000	
7	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	2100000	
8	БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	150000	
	Нийт дүн	8,734,000	

МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БОУАӨЯ-ны сайдын 2019-10-29-ны №А/618 тушаал “Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”
- “Агар энерги” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт хэрэгжүүлэх “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн аж ахуй /”М-Си-Эс Кока-Кола” үйлдвэрийг технологийн уур, дулаан, хүнсний зориулалттай нүүрсхүчлийн хийгээр хангах”/ төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан
- “Агар энерги” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт хэрэгжүүлэх “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн аж ахуй /”М-Си-Эс Кока-Кола” үйлдвэрийг технологийн уур, дулаан, хүнсний зориулалттай нүүрсхүчлийн хийгээр хангах”/-н Байгаль орчны 5 жилийн менежментийн төлөвлөгөө